



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

Хөрөнгийн зах зээл

Э-СОНИН

2020

4-P CAP

Х.Алтай: Дотоодын
хөрөнгийн зах зээлийн
бүтэц хэт нүсэр байна

T+2 горимын эхний
төлбөр тооцоо
амжилттай хийгдлээ

"Хөрөнгөөр
баталгаажсан үнэт
цаасны бүртгэлийн
журам"
батламжлагдлаа





Зах зээлийн тойм

/2020.04.30-ны өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр

2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/

Хувьцаа /анхдагч/

Хувьцаа /хоёрдогч/

Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/

Компанийн бонд /анхдагч/

Компанийн бонд /хоёрдогч/

3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг

Хувьцаа /анхдагч/

Хувьцаа /хоёрдогч/

Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/

Компанийн бонд /анхдагч/

Компанийн бонд /хоёрдогч/

4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо

22

2,281,079,471


2,281,079,471

9,479,377


9,479,377

3,296


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	198
100% төрийн өмчит	18
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	170
I ангилал	14
II ангилал	44
III ангилал	140

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	54
Үүнээс: Брокер, Дилер	54
Андеррайтер	19
Хөрөнгө оруулалтын зөвлөх	14



Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2020.04.30-ны байдлаар/

	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (төг)
		Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	
1	ЕВРАЗИА КАПИТАЛ МОНГОЛИА ҮЦК ХХК	2,317,799	695,339,700	2,317,799	695,339,700	1,390,679,400
2	АРД СЕКЮРИТИЗ ҮЦК ХХК	1,368,336	359,892,403	1,285,407	323,673,277	683,565,680
3	БИДИСЕК ҮЦК ХК	1,288,617	401,951,102	561,990	278,131,215	680,082,317
4	СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК	681,803	228,980,435	1,056,709	291,422,821	520,403,257
5	АРГАЙ БЭСТ ҮЦК ХХК	51,240	243,351,290	59,744	244,802,848	488,154,138
6	ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК	424,783	31,139,369	1,849,920	144,000,644	175,140,013
7	ТИ ДИ БИ КАПИТАЛ ҮЦК ХХК	205,187	49,171,321	726,112	60,888,407	110,059,728
8	БУМБАТ-АЛТАЙ ҮЦК ХХК	571,267	39,065,508	166,214	27,336,723	66,402,231
9	ЦЕНТРАЛ СЕКЬЮРИТИЗ ҮЦК ХХК	348,486	43,780,442	21,481	6,995,306	50,775,748
10	АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК	310,723	26,594,367	199,992	21,107,680	47,702,046
11	МИРЭ ЭССЕТ СЕКЬЮРИТИС МОНГОЛ ҮЦК ХХК	843,878	30,149,966	332,909	13,616,285	43,766,251
12	ТУЛГАТ ЧАНДМАНЬ БАЯН ҮЦК ХХК	0	0	104,623	41,884,248	41,884,248
13	НОВЕЛ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК	5,835	2,751,024	161,373	39,070,206	41,821,230
14	СИКАП ҮЦК ХХК	608,785	41,524,858	250	6,255	41,531,113
15	АРД КАПИТАЛ ГРУПП ҮЦК ХХК	62,677	14,304,039	70,764	22,032,893	36,336,932
16	ГАУЛИ ҮЦК ХХК	28,895	4,533,819	240,533	19,395,041	23,928,860
17	ГҮҮДСЕК ҮЦК ХХК	191,047	15,913,971	114,344	5,081,523	20,995,493
18	ЛАЙФТАЙМ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК	3,238	16,831,615	0	0	16,831,615
19	ГАЦУУРТ ТРЕЙД ҮЦК ХХК	65,022	13,115,620	0	0	13,115,620
20	ЭС ЖИ КАПИТАЛ ҮЦК ХХК	0	0	64,777	13,019,825	13,019,825

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2020.04.30-ны байдлаар/

№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн (төг)	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /%/
1	MDR	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	2,317,879	695,366,900	340	300	-11.76
2	APU	АПУ	395,874	213,063,808	543	520	1.22
3	SUL	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	2,234	178,092,400	80,000	65,000	28.64
4	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	115,718	170,932,158	1,519	1,380	-2.44
5	AIC	АРД ДААТГАЛ	144,623	101,426,248	720	652	-1.39
6	DAZ	ДОРНОД АВТО ЗАМ	38,809	100,127,220	2,580	2,580	0.00
7	EER	АРИГ ГАЛ	34,507	99,960,760	3,000	2,890	-6.77
8	NEH	ДАРХАН НЭХИЙ	6,560	85,282,700	13,100	13,000	-1.52
9	LEND	ЛЭНДМН ББСБ	2,307,895	80,069,335	39	30	20.08
10	TTL	ТАВАН ТОЛГОЙ	15,630	79,586,514	6,250	4,200	-21.18
11	ADB	АРД КРЕДИТ ББСБ	1,065,672	79,144,869	78	70	-4.32
12	GOV	ГОВЬ	420,837	78,632,972	205	161	15.20
13	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	1,249,328	55,673,029	47	43	-3.58
14	MFC	МОНОС ХҮНС	690,716	45,754,551	69.9	65.1	2.70
15	GHC	ГАН ХИЙЦ	3,399	40,788,000	12,000	12,000	-4.00
16	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	813	21,914,920	31,000	23,000	29.17
17	TUM	ТҮМЭН ШУВУУТ	132,402	18,776,736	150	137	-0.07
18	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	83,154	17,012,816	221	200	-2.45
19	INV	ИНВЕСКОР ББСБ	5,927	14,828,816	2,670	2,291	0.48
20	AMT	ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС	64,777	13,019,825	225	198	21.10



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2020.04.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %/
			2020-03-31	2020-04-30		
1	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	813	24,000.00	31,000.00	7,000.00	29.17
2	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	2,234	62,150.00	79,950.00	17,800.00	28.64
3	ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС	64,777	185.80	225.00	39.20	21.10
4	ЛЭНДМН ББСБ	2,307,895	29.98	36.00	6.02	20.08
5	СҮҮ	24,307	181.60	212.00	30.40	16.74
6	ГОВЬ	420,837	173.78	200.19	26.41	15.20
7	МОНГОЛ ДИЗЕЛЬ	1	410.63	472.22	61.59	15.00
8	ХӨСӨГ ТРЕЙД	10	1,950.00	2,242.00	292.00	14.97
9	МОННООС	6,140	1,950.00	2,240.00	290.00	14.87
10	БИ ДИ СЕК	286	802.00	896.00	94.00	11.72
11	АВТО ЗАМ	8	3,100.00	3,290.00	190.00	6.13
12	УБ-БҮК	28,967	396.00	419.99	23.99	6.06
13	РЕМИКОН	59,461	24.00	25.00	1.00	4.17
14	МЕРЕКС	1,505	15.00	15.60	0.60	4.00
15	ХАЙ БИ ОЙЛ	1,670	62.99	65.00	2.01	3.19
16	ШИВЭЭ ОВОО	2	1,925.00	1,980.00	55.00	2.86
17	МОНОС ХҮНС	690,716	67.00	68.81	1.81	2.70
18	АЙТҮҮЛС	147,594	73.32	75.00	1.68	2.29
19	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	14,750	500.10	508.00	7.90	1.58
20	АПУ	395,874	533.64	540.14	6.50	1.22

Ханшийн бууралттай хувьцаа

/2020.04.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %
			2020-03-31	2020-04-30		
1	СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП	47,715	80.00	41.62	-38.38	-47.98
2	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	309	5,700.00	4,250.00	-1,450.00	-25.44
3	АГРОТЕХИМПЕКС	105	900.00	700.00	-200.00	-22.22
4	ТАВАН ТОЛГОЙ	15,630	6,250.00	4,926.00	-1,324.00	-21.18
5	ШАРЫН ГОЛ	774	1,199.00	977.00	-222.00	-18.52
6	БАГАНУУР	814	993.00	825.00	-168.00	-16.92
7	МОН-ИТ БУЛИГААР	15	7,200.00	6,000.00	-1,200.00	-16.67
8	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	6,518	1,077.00	900.00	-177.00	-16.43
9	СОР	38	1,000.00	850.00	-150.00	-15.00
10	УВС ЧАЦАРГАНА	120	300.00	255.00	-45.00	-15.00
11	АЗЫК	485	2,972.00	2,560.00	-412.00	-13.86
12	МОНГОЛЫН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	7	5,150.00	4,500.00	-650.00	-12.62
13	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	2,317,879	340.00	300.00	-40.00	-11.76
14	МОНГОЛ СЕКЮРИТИЕС	197	280.00	250.00	-30.00	-10.71
15	МОГОЙН ГОЛ	18	7,700.00	7,000.00	-700.00	-9.09



Т+2 ГОРИМЫН ЭХНИЙ ТӨЛБӨР ТООЦОО АМЖИЛТТАЙ ХИЙГДЛЭЭ

Үнэт цаасны зах зээлийн арилжааг идэвхжүүлэх, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн байгууллагуудын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор гаргасан СЗХ-ны 2020 оны 1-р сарын 29-ны өдрийн 29 тоот тогтоол, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХХК, "Арилжааны төлбөр тооцоо ҮЦК" ТӨХХК зэрэг байгууллагуудын 2020 оны 3-р сарын 27-ны өдрийн А25/А10/А31 тоот хамтарсан тушаалын дагуу Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжааны дараах үйл ажиллагааг 2020 оны 3-р сарын 31-ний өдрөөс клирингийн гишүүнчлэл бүхий шинэ үйлчилгээ, төлбөр тооцооны Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт (DvP) зарчимд шилжүүлсэн билээ.

Уг горимын дагуу 2020 оны 3-р сарын 31-ний өдөр явагдсан **561,644,042.53** төгрөгийн үнийн дүн бүхий арилжааны төлбөр тооцоо өнөөдөр 11:00 цагт төлбөр тооцооны Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт (DvP) зарчмын дагуу амжилттай хийгдэж, 31 төрлийн 1.05 сая ширхэг хувьцааны өмчлөх эрх баталгаажлаа.

"АРИЛЖААНЫ ЖУРАМ"-Д НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРЛОО

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар 07-ны өдрийн 2020/07 тоот тогтоолоор баталсан "Арилжааны журам"-ын нэмэлт өөрчлөлтийг СЗХ-ны даргын 2020 оны 3-р сарын 19-ны 123 тоот тушаалаар батламжилсан байна. Уг нэмэлт өөрчлөлтөөр МХБ-ийн арилжааны хэлцэл баталгаажуулах, хэлцэл цуцлах зэрэг нарийвчилсан зохицуулалтуудыг тусгаснаас гадна хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, сангийн нэгж эрх зэргийг арилжих, тэдгээрийн арилжааны шимтгэл хураамжийн талаар нэмж орууллаа.

"ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ" БАТЛАМЖЛАГДЛАА

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн 2020/06 дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 146 тоот тушаалаар батламжиллаа. Олон улсын жишигт банк,

санхүүгийн байгууллагууд активаа багцлан үнэт цаасжуулж, хөрөнгийн зах зээлд худалдан санхүүжилт татах замаар эрсдэлээ хуваалцах нь түгээмэл байдаг бөгөөд энэ төрлийн үнэт цаас арилжигдаж эхэлснээр банк, санхүүгийн байгууллагуудад хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилтийн шинэ суваг нээгдэх, иргэдэд тогтмол хугацаат хүүгийн орлого бүхий эрсдэл харьцангуй багатай хөрөнгө оруулалтын шинэ бүтээгдэхүүн санал болгох боломж бүрдэх юм.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС СЭРЭМЖЛҮҮЛЖ БАЙНА

Монгол Улсын 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс өмнө төрсөн иргэдэд эзэмшүүлсэн "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн 1072 ширхэг хувьцаатай холбоотой олон нийтийн цахим сүлжээнд худал ташаа мэдээлэл, сурталчилгаа тавигдах боллоо.

Тухайлбал Facebook олон нийтийн сүлжээнд "1072 хувьцаа авна", "1072 хувьцаа бэлэн мөнгөөр авна", "1072 хувьцаа худалдаж авна, данс нээнэ" гэх зэрэг зар мэдээлэл нь иргэд, олон нийтийг залилан мэхэлж болзошгүй гэмт хэргийн шинжтэй, зөвхөн пэйж хуудсаа олон хүний хандалттай болгох гэсэн зорилготой үйлдэл гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолын хүрээнд "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн иргэдэд эзэмшүүлсэн хувьцаа нь захиран зарцуулахгүй байх нөхцөлтэй буюу арилжаалагдах, бусдад шилжүүлэх боломжгүй бөгөөд Хорооны үнэт цаасны зах зээлд тусгай зөвшөөрөлтэй, зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага болон "Эрдэнэс-Тавантолгой" ХК-д хандан 1,072 хувьцаатай холбоотой мэдээ, мэдээллийг авах боломжтой.

Иймд иргэд та бүхэн 1,072 хувьцаатай холбоотой цахим сүлжээн дэх албан бус мэдээлэл, сурталчилгаанд хууртагдахгүй байх, бусдад залилан мэхлүүлэхгүй байхыг сэрэмжлүүлж байна.



"АРД КРЕДИТ ББСБ" ХК ОЛОН НИЙТЭЭС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН ИРҮҮЛЛЭЭ

Монголын хөрөнгийн биржид 2019 онд шинээр үнэт цаасаа бүртгүүлж, олон нийтээс 5.2 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн "Ард Кредит ББСБ" ХК нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах байдлаар зарцуулсан тухай тайлан ирүүлсэн байна. Үүнд:

- Бизнесийн зээл -2.8 тэрбум төгрөг;
- Хэрэглээний зээл -612.5 сая төгрөг;
- Шуурхай зээл -980.0 сая төгрөг;
- Кредит карт -367.5 сая төгрөг;
- Ард аппликэйшн -49.0 сая төгрөг;
- Хувьцаа барьцаалсан зээл -122.5 сая төгрөг.

Үйл явдал

"ТАВАНТОЛГОЙ" ХК НОГДОЛ АШИГ ТАРААХААР БОЛЛОО

"Тавантолгой" ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 04-р сарын 29-ний өдрийн № 04 тоот тогтоолоор нэгж хувьцаандаа 821 төгрөг буюу 43.2 тэрбум төгрөгийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчдэдээ тараахаар болов.

Энэхүү ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр буюу 2020 оны 4 дүгээр сарын 03-ны өдрөөр тогтоох бөгөөд 2020 оны 5-р сарын 31-ний дотор "ҮЦТХТ" ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэв.



ХАЛТАЙ: ДОТООДЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЦ ХЭТ НҮСЭР БАЙНА



Нэн тэргүүн COVID 19 Монголын хөрөнгийн зах зээлийн хаалгыг тогтсон уу гэж асуумаар байна. Эсвэл хэдийнэ босго давж орчихоод бужигнуулж байж ч болох юм. Аливаа савлагаа, эрсдэлд хамгийн түрүүн хөрөнгийн зах зээл өртөж, хамгийн түрүүн сэргэдэг учраас ингэж асууж байна. Тийм бол яаж, ямар байдалтай болж байна, үгүй бол яагаад?

Аливаа улсын хөрөнгийн зах зээл бол эдийн засгийн толь байдаг бөгөөд хамгийн түрүүнд өөрчлөлт үзүүлж дохио өгдөг. COVID 19 цар тахалтай холбоотойгоор дэлхийн том, жижиг бүхий л биржийн арилжааны идэвх эрс суларч, томоохон индексүүд 20-30 хувийн уналттай явж байна.

Манай зах зээлийн хувьд ТОП-20 буюу идэвхтэй арилжигддаг 20 үнэт цаасны үнийн индекс оны эхнээс хойш 12 хувиар, MSE A буюу нэгдүгээр ангиллын үнэт цаасны үнийн индекс 17 хувиар, MSE B буюу үнэт цаасны хоёрдугаар ангиллын үнэт цаасны үнийн

Үйл явдал

индекс гурван хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Зах зээлийн үнэлгээ мөн долоо орчим хувиар буурсан. Өнгөрсөн хоёр болон гуравдугаар саруудад өмнөх оны мөн үеэс арилжааны үнийн дүн зургаа дахин болон 10 дахин тус тус буурсан үзүүлэлттэй байна. Арилжааны үнийн дүн ийнхүү буурахад вирусийн дэгдэлттэй холбоотойгоор шинээр үнэт цаас гаргах ажиллагаа буюу IPO хойшлогдсон, хоёрдогч зах зээлийн арилжааны идэвх суларсан нь нөлөөлсөн.

Ер нь энэ онд Монгол дахь хөрөнгийн зах зээлийн арилжаа, идэвх ямар байна гэж төсөөлж байсан бэ? Төсөөлөлтэй харьцуулахад, төсөөллөөс нөхцөл байдал эрс буурсан тохиолдолд Монголын эдийн засагт хэрхэн нөлөөлөх бол?

Сүүлийн жилүүдэд буюу 2017-2019 онд дотоодын хөрөнгийн зах зээл идэвхжиж, олон шинэ үнэт цаас бүртгэгдсэн. Тухайлбал, 2017 онд Монголын хөрөнгийн бирж түүхэндээ анх удаа 859.2 тэрбум төгрөгийн арилжаа хийж, ТОП-20 индекс 68.9 хувиар, зах зээлийн үнэлгээ 67.4 хувиар тус тус өссөн, 2018 онд хамгийн олон компани үнэт цаасаа бүртгүүлсэн түүхэн дээд амжилт тогтоосны зэрэгцээ үнэт цаасны анхны давхар бүртгэл, даатгалын компанийн үнэт цаас бүртгэгдсэн онцлог үйл явдал тохиосон бол 2019 онд үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа хамгийн өндөр түвшинд буюу 42.5 тэрбум төгрөгт хүрсэн.

2020 онд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор анхдагч зах зээлийн арилжааны дээрх хэмжээ хадгалагдах, үүнийг дагаад хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн дүн өсөх хүлээлттэй байсан боловч өнөөдрийн нөхцөл байдлаас шалтгаалан дээрх төлөвлөгөө хэрэгжихэд хүндрэл үүсэх төлөвтэй болоод байна.

2020 онд ХБ-д бүртгэлтэй компаниуд хөрөнгөөр баталгаажуулсан үнэт цаасаа гаргана гэж байсан. Шинэ бүтээгдэхүүнд энэ онд гарах болов уу?

Бид ХБҮЦ-ыг зах зээлд нэвтрүүлэх үүднээс энэ онд

“Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг шинээр боловсруулан ТУЗ-өөрөө батлуулж, саяхан СЗХ-гоор батламжлуулаад байна. Энэхүү журмын дагуу дотоодын хөрөнгийн зах зээлд тогтмол орлоготой, эрсдэл харьцангуй багатай шинэ төрлийн бүтээгдэхүүн бий болж, эдийн засаг дахь илүүдэл хөрөнгийг хөрөнгийн зах зээлд оруулж ирэх боломж бүрдлээ. Биржийн зүгээс ХБҮЦ гаргах боломжтой компаниудтай хамтран ажиллаж байгаа бөгөөд ойрын үед манайд бүртгэлтэй компаниуд



ХБҮЦ гаргах төлөвтэй байна.

УИХ Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах арга хэмжээг баталлаа. Энэ арга хэмжээ хөрөнгийн зах зээлд хэрхэн нөлөөлж, үр дүнгээ өгнө гэж харж байна? Өгөхгүй бол яагаад?

Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах арга хэмжээний хүрээнд аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих, иргэдийн зээлийн төлбөрийг хойшлуулах, ялангуяа хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааг дэмжих зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр заасан нь хөрөнгийн зах зээлд эерэгээр нөлөөлнө гэж харж байна.

Монголын хөрөнгийн бирж МГТ платформын ашиглалтын зардалд 2019 онд гэхэд л 1.1 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн тухай та мэдэгдэж байсан. Ийм байдлаар алдагдал хэр удаан үргэлжлэхээр байна вэ? Энэ зардлыг задлавал юу юуны төлбөр бол? Цаашид хөрөнгийн зах зээлд оролцогчид үүнийг хувааж төлөх ёстой гэж байсан. Гэтэл тэдний эх үүсвэр угтаа хувьцаа эзэмшигчдээс, татвар төлөгчдөөс гардаг шүү дээ?

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр дотоодын хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх зорилгоор 2011 онд Лондонгийн хөрөнгийн бирж групптэй Стратеги хамтын ажиллагааны “Ажлын мастер гэрээ”-г байгуулж, гэрээний хүрээнд Миллениум Ай Ти цогц системийг дотоодын хөрөнгийн зах зээлд 2012 оны 7 сард албан ёсоор нэвтрүүлсэн. Уг цогц систем нь үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хадгаламж, хяналтын дэд системүүдээс бүрддэг бөгөөд системийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “Арилжаа төлбөр тооцоо” ХХК, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны компаниуд нийт зах зээлийн хэмжээнд ашиглаж байна. Гэтэл МХБ нь системийн аюулгүй найдвартай тасралтгүй ажиллагааг бүхэлд нь хариуцдаг бөгөөд системийн ашиглалт болон элэгдэл хорогдолтой холбоотой бүхий л зардлыг санхүүгийн тайландаа тусгадаг. Засгийн газрын шийдвэрээр АМГ-ний хүрээнд системийн холбогдох төлбөрүүдийг Улсын нэгдсэн төсвөөс санхүүжүүлдэг байсан боловч 2018 оноос эхлэн МХБ өөрийн үйл ажиллагааны

орлогоос хариуцах болсон. Нэгэнт системийг зах зээлийн хэмжээнд ашиглаж байгаа тул зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд холбогдох зардлыг хувааж төлөх нь зүйтэй гэсэн хатуу байр суурьтай байна.

Ер нь анхнаасаа дутуу функцтэй, их үнэтэй технологийг энэ жижиг зах зээлд оруулж ирсэн нь буруу гэдэг шүүмжлэл бий. Та энэ МГТ платформ хэр үр дүнгээ өгсөн, өгч байгаа гэж үздэг вэ?

Өнөө цагт аливаа хөрөнгийн биржийн зардлын бүтцэд технологийн зардал хамгийн өндөр зардлын нэг байдаг бөгөөд үүний цаад шалтгаан нь арилжаа шударга, ил тод, нээлттэй, тасалдалгүй явагдах нөхцөлийг хангах, хөрөнгө оруулагчид болон үнэт цаас гаргагчдын итгэлийг хүлээсэн системтэй байхыг чухалчилдагтай холбоотой.

Түүнчлэн, олон улсын хөрөнгийн биржүүдийн нийтлэг бүтэц нь арилжаа, төлбөр тооцоо зэрэг дэд бүтцийн байгууллагууд нь нэгдмэл буюу группийн бүтэцтэй байдаг тул бүх зардлаа орлогоороо санхүүжүүлэх бүрэн боломжтой байдаг. Манай зах зээлийн хувьд хэт данхагар олон салангид байгууллагууд төрийн өмчит хэлбэрээр тус тусдаа үйл ажиллагаа явуулдаг бөгөөд зах зээлийн хэмжээнд ашиглаж буй системийн





төлбөрийг МХБ дангаараа хариуцаж байгаа нь хүндрэл учруулж байна.

Миллениум Ай Ти платформын хувьд олон улсын чанарын ISO 9001:2008 сертификаттай, дэлхийн 20 гаруй улсад ашиглагддаг бөгөөд тус платформ нь арилжааны бодит горимын хяналт, онлайн арилжааг нэвтрүүлж арилжааны өртөг зардал, цаг хугацааг хэмнэх нөхцөлийг бий болгосон. Өнөөдөр хөрөнгийн биржийн өдөр тутмын арилжааны 50 гаруй хувь нь онлайнгаар хийгдэж байна.

Манай бирж ОУ-д төрийн эзэмшлийн цор ганц бирж нь. Хувьчлах асуудал хэрхэн яригдаж байгаа бол? Хувьд шилжүүлэх тал дээр таны байр суурь?

Дэлхийн томоохон хөрөнгийн биржүүдийг харахад бүгд төрийн өмчийн бус, нээлттэй хувьцаат компанийн хэлбэртэй байдаг. Ингэснээр биржүүд зах зээлээ мэдэрсэн шинэ бүтээгдэхүүнийг цаг алдалгүй гаргаж, өөрийн үйл ажиллагаа, үйлчилгээний хүрээгээ бизнесийн зарчмаар тогтоож, оновчтой бүтцээр үйл ажиллагаа явуулж, шимтгэл хураамжаа зах зээлд дарамт багатай хэмжээнд тогтоох боломжтой байдаг.

Хэрвээ хувьчлагдах шийдвэр гарвал МХБ нээлттэй хувьчлалын сайн жишээ болж чадна гэдэгт эргэлзэхгүй байна. Бирж нээлттэй хувьцаат компани болсноор зах зээлд илүү үр дүнтэй үйл ажиллагаа явуулах боломжтой болно.

Монголын хөрөнгийн зах зээл Т+2 үйлчилгээг гаргалаа. Төлбөр тооцооны энэ шинэ горимд шилжснээр Монголын үнэт цаасны арилжаанд ямар өөрчлөлт, үр дүн бий болох вэ?

Монголын хөрөнгийн зах зээл төлбөр тооцооны Т+2 горимд 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр амжилттай шилжлээ. Энэхүү шилжилт нь арилжааны төлбөр тооцооны процесс олон улсын жишигт хүрч хөгжих, манай зах зээл олон улсын зах зээлийн зэрэглэлтэй болоход нэн чухал алхам болсон бөгөөд үүний үр дүнд зах зээлийн хөрвөх чадвар сайжрах, гадаадын хөрөнгө оруулагчид нэмэгдэх зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Хөрөнгийн зах зээлд ажил үйлчилгээ эрхлэгчид төдийгүй хэн хүнгүй “ЭТТ” ХХК-ийн хувьцааны ногдол ашиг, цаашлаад хувьцааны арилжаа энэ салбарын үйл ажиллагааг идэвхижүүлж хөдөлгөөнд оруулна гэсэн хүлээлттэй байна.

Таныхаар тус компанийн арилжаа хоёрдогч зах зээлд шилжснээр ямар давуу тал, боломжийг Монголын хөрөнгийн зах зээлд бий болгох бол? Хөрөнгийн биржийн хүлээлт ямар байна?

“Эрдэнэс тавантолгой” ХК нь одоогийн байдлаар хөрөнгийн биржид бүртгэгдэж арилжаалж эхлээгүй байгаагаас иргэд өөрийн эзэмшлийн хувьцаагаа захиран зарцуулж, эдийн засгийн эргэлтэнд оруулах боломжоор хангагдаагүй байна. Хэрэв тус компанийн үнэт цаасны дотоодын хөрөнгийн биржийн арилжааг нэн яаралтай эхлүүлвэл иргэд хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэгээ нэмэгдүүлж хувьцаагаа арилжаалах замаар бэлэн мөнгөтэй болохоос гадна гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, зах зээлийн хөрвөх чадвар нэмэгдэх, цаашлаад иргэдийн гар дээр очих мөнгө худалдаа үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдэд очих зэргээр цар тахлын энэ хүнд үед эдийн засгийг дэмжих өндөр ач холбогдолтой алхам болох юм.

Түүнчлэн, тус компани 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тараах 200 орчим тэрбум төгрөгийн ногдол ашиг нь Ковид-19 цар тахлын үед эдийн засгийг дэмжих бас нэгэн чухал арга хэмжээ болно.

Монголын хөрөнгийн зах зээл жижиг хэрнээ оролцогч олонтой, нүсэр бүтэцтэй гэж та өмнө нь мэдэгдэж байсан. Ингэж үзэх шалтгаан нь, ямар өөрчлөлт хийж болох уу?

Манай хөрөнгийн зах зээлийн арилжааны шимтгэл нь бусад зах зээлүүдтэй харьцуулахад өндөр байдаг нь зах зээлд хөрөнгө оруулах сонирхлыг бууруулах, өдрийн арилжаа /day trade/ зэрэг их давтамжтай арилжаанаас ашиг олох боломжийг хязгаарладаг. Арилжааны шимтгэл нь үнэт цаасны компаниуд, хөрөнгийн бирж, арилжааны төлбөр тооцооны байгууллага, зохицуулагч байгууллага зэрэг олон байгууллагуудын шимтгэл хураамжаас бүрддэг тул өртөг зардлыг бууруулахын тулд олон улсын стандартын дагуу зах зээлийн нэгдмэл, оновчтой бүтэц, зохион байгуулалтыг бий болгох шаардлагатай байна.

МХБ нь нэгдсэн группийн бүтэцтэй болсноор өртөг зардлыг хэмнэж, эцсийн хөрөнгө оруулагчийн арилжааны шимтгэлийг бууруулахаас гадна хөрөнгийн зах зээл хөгжлийн нэгдсэн бодлогоор хангагдах ач холбогдолтой юм.

Ярилцсан :Сэтгүүлч Д.Даваадулам



"МОНОС ГРУПП" ХХК-ААС "БИД ХАМТДАА СЭРГИЙЛЖ ЧАДНА" УРИАЛГЫГ ГАРГАЖ БАЙНА

Дэлхий дахинд өргөн хүрээнд тархаж байгаа коронавирусийн (Covid-19) халдвараас Монгол Улсын иргэн бүрийг хамгаалахын төлөө улс даяар урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор "Монос групп" ХХК нь холбогдох байгууллагуудаас гаргаж байгаа шийдвэрийг хариуцлагатайгаар биелүүлж байгаа иргэн, байгууллага бүрийг цаашид өндөр хариуцлагатай байж, хичээл зүтгэл гарган эрсдлээс хамгаалахыг уриалж, "Бид хамтдаа сэргийлж чадна" аяныг өрнүүлж байна.

Уг аяны хүрээнд "Монос групп" ХХК-аас "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн нийт ажиллагсад 500 ширхэг амны хаалтыг бэлэглэв.

Дашрамд дурдахад, "Монос групп" ХХК-ийн охин компани болох Монос Хүнс" ХК нь эрүүл



мэндийн салбараас анх удаа олон нийтэд нийт хувьцааныхаа 30 хувь буюу 122,655,128 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 70 төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдаал, нийт 8.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүлж бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх болон техник технологийг сайжруулан ажиллаж байгаа билээ.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-Д БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН 2020 ОНЫ 5 ДУГААР САРД БОЛОХ ХОЙШЛОГДСОН ЭЭЛЖИТ БОЛОН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

№	Компанийн нэр	Цаг	Өдөр	Тайлбар
1	ХАСУ-МАНДАЛ ХК	16:00	2020.05.09	Ээлжит бус
2	БАЯНТЭЭГ ХК	10:00	2020.06.29	Ээлжит бус
3	УЛААНСАН ХК	15:00	2020.05.13	Ээлжит бус
4	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХК	16:00	2020.05.27	Ээлжит бус
5	22-Р БААЗ ХК	13:00	2020.05.28	Ээлжит бус
6	МОНГОЛ СЕКЬЮРИТИЗ ХК	13:00	2020.05.04	Ээлжит бус
7	МОНИНЖБАР ХК	11:00	2020.05.04	Хойшлогдсон ээлжит хурал
8	ХЭРЛЭН ХИВС ХК	10:00	2020.05.07	Хойшлогдсон ээлжит хурал
9	МОГОЙН ГОЛ ХК	14:00	2020.05.08	Хойшлогдсон ээлжит хурал
10	ЖЕНКО ТУР БЮРО ХК	09:30	2020.05.13	Хойшлогдсон ээлжит хурал
11	ЭРЧИМ БАЯН ӨЛГИЙ ХК	16:00	2020.05.14	Ээлжит бус
12	МОНГОЛ ШИЛТГЭЭН ХК	13:00	2020.05.25	Хойшлогдсон ээлжит хурал
13	ИНГЭТ ТОЛГОЙ ХК	10:00	2020.06.20	Ээлжит бус
14	НОМИН ХИШИГ ХК	10:00	2020.06.21	Ээлжит бус
15	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРП ХК	16:00	2020.06.25	Ээлжит



2019 ОНЫ ЦЭВЭР АШГААС ТАРААГДАХ НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төгрөг/	Нэгж хувьцаанд олгосон ногдол ашиг /төг/	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр	Хуваарилах хэлбэр
1	ATR	Атар-Өргөө ХК	60.9	350	2020.04.01	2020.08.01	ҮЦТХТ
2	ADB	Ард кредит ББСБ ХК	1184.6	4.23	2020.04.08	2020.06 дотор	ҮЦТХТ
3	APU	АПУ ХК	75471.2	71	2020.03.23	2020.08 дотор	ҮЦТХТ
4	TCK	Талх чихэр ХК	230.3	225	2020.04.03	2020.06.20	ҮЦТХТ
5	AIC	Ард даатгал ХК	850	34	2020.04.09	2020.06 дотор	ҮЦТХТ
6	MBW	Монгол базальт ХК	255.6	4	2020.03.09	2020.06 дотор	ҮЦТХТ
7	BDS	Би ди сек ХК	136.9	10	2020.03.09	2020.12 дотор	ҮЦТХТ
8	NEH	Дархан нэхий ХК	232.1	210	2020.02.25	2020.09 хойш	ҮЦТХТ
9	LEND	ЛэндМН ББСБ ХК	1200	1.5	2020.02.25	2020.04 дотор	ҮЦТХТ
10	MNP	Монгол шуудан ХК	331	3.3	2020.04.05	2020.05.01-с	ҮЦТХТ
11	HRD	Хүрд ХК	72.3	535	2020.03.02	2020.06 дотор	ҮЦТХТ
12	HRM	Гермес центр ХК	322	4.1	2020.02.28	2020.03.15	ҮЦТХТ
13	BUK	УБ-бүк ХК	526.2	4	2020.04.05	2020.06.01	ҮЦТХТ
14	UBH	УБ хивс ХК	121.4	300	2020.03.06	2020.05.01-с	ҮЦТХТ
15	TAH	Тахь-ко ХК	128.5	108	2020.04.05	2020.04 дотор	ҮЦТХТ
16	AARD	Ард санхүүгийн нэгдэл ХК	1000	34.95	2020.04.07	2020.04 дотор	ҮЦТХТ
17	MNDL	Мандал даатгал ХК	2490	4	2020.04.10	2020.06 дотор	ҮЦТХТ
18	BNG	Баянгол ЗБ ХК	152.3	360	2020.04.05	2020.09.01-с	ҮЦТХТ
19	MMX	Мах импекс ХК	456	120	2020.04.03	2020.10.01-с	ҮЦТХТ
20	JTB	Женко тур бюро ХК	799.8	10	2020.03.27	2020.06.30-ны дотор	ҮЦТХТ
21	TEX	Техник импорт ХК	723.3	500	2020.03.11	2020.04.24-с	Компанийн байран дээр
22	MFC	Монос хүнс ХК	408.8	1	2020.03.11	2020.08.31-с	ҮЦТХТ
23	MCH	Монголын цахилгаан холбоо ХК	25.8	1	2020.04.06	2020.06.01-с	ҮЦТХТ
24	HUV	Хөвсгөл геологи ХК	21.5	150	2020.04.03	2020.05.01-с	ҮЦТХТ
25	GTL	Гутал ХК	2403.6	1520	2020.03.13	2020.05.05-с	ҮЦТХТ
26	HZB	Ган Хэрлэн ХК	14.9	150	2020.03.18	2020.09.30 дотор	ҮЦТХТ
27	BTG	Баян тээг ХК	500	1979.3	2020.04.07	2020.12.01 дотор	ҮЦТХТ
28	SUU	Сүү ХК	1715.1	5	2020.03.27	2020.05.01-12.31	
29	EER	Ариг гал ХК	32.49	109.4	2020.03.27	2020.06.30 дотор	ҮЦТХТ
30	TUM	Түмэн шувуут ХК	4.80	3200	2020.04.07	2020.06.24	ҮЦТХТ
31	DSS	Дархан сэлэнгийн цахилгаан түгээх ХК	37.73	391.8	2020.03.20	2020.09.02	ҮЦТХТ
32	TTL	Таван Толгой ХК	43238.2	821	2020.04.03	2020.05.31 дотор	ҮЦТХТ



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХ ГЭЖ ЮУ ВЭ?


2019 оны "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн шинээр боловсруулж батлуулсан "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын дагуу иргэд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх буюу багц үнэт цаасанд хөрөнгө оруулах боломж бүрдэх юм.

"ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС ГЭЖ ЮУ ВЭ?"

Энэ онд МХБ-ийн шинээр боловсруулж батлуулсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу манай зах зээлд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд нээлттэй арилжих боломжтой боллоо.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ ЭРХ ГЭЖ ЮУ ВЭ?

2019 онд "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн шинээр боловсруулж батлуулсан "Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ын дагуу иргэд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх буюу багц үнэт цаасанд хөрөнгө оруулах боломж бүрдэх юм.



МЭРГЭЖЛИЙН ОНОВЧТОЙ УДИРДЛАГААР ХӨРӨНГӨӨ УДИРДУУЛСНААР ИРГЭД ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОХОД ИЛҮҮ ХЯЛБАР БОЛНО.

ОЛОН НИЙТИЙН ХӨРӨНГИЙГ НИЙЛҮҮЛЖ ИХ ХЭМЖЭЭНИЙ САНГ БҮРДҮҮЛЭХ НЬ ЗАХ ЗЭЭЛЭЭС ХӨРӨНГӨ ТАТАХААР ХАЙЖ БҮЙ ОЛОН БИЗНЕСҮҮДЭД УРТ ХУГАЦААНЫ ЭХ ҮҮСВЭР ТАТАХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛДНЭ.

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС ГЭЖ ЮУ ВЭ?

2020 оны 2 дугаар сард "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн шинээр боловсруулж батлуулсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу манай зах зээлд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд нээлттэй арилжих боломжтой боллоо.



Банк, санхүүгийн байгууллагын хувьд шинээр эх үүсвэр татаж, шинэ зээлдэгчдэд зээл олгох, хөрвөх чадвараа сайжруулах боломж юм.



Хөрөнгө оруулагчдын хувьд өөрийн хүсч буй эрсдэл, өгөөжийн түвшинд нийцэх, тогтмол хугацаанд хүүгийн орлого олгох санхүүгийн хэрэгслийг сонгон хөрөнгө оруулж, хөрөнгөө өсгөх боломж юм.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гэдэг нь иргэд, байгууллагуудад олгосон зээлийн эргэн төлөлтийн баталгаа, барьцааг үндэслэж, тухайн зээлүүдийг багцлан шинэ үнэт цаас болгон гаргасныг хэлдэг.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

МОНГОЛЧУУДЫН ХООЛЛОЛТ БА ХОДООДНЫ ӨВЧЛӨЛ

Монголчууд бид эртнээс хүйтний улиралд уураг ихтэй махан хоол хүнс хэрэглэж дулааны улиралд ходоодоо амрах зорилгоор махан хоолноос татгалзсаар иржээ. Махан хоол их хэрэглэдэг эдгээр үеүүддээ ходоодны орчноо тэнцвэржүүлэх зорилгоор хужраар амталж хэрэглэдэг байсан аж. Сүүлийн нэг жарны туршид бидний дийлэнх нь суурин иргэншилд шилжиж өвөл зунгүй махан хоол хүнс хэрэглэх болсон нь эрүүл мэндэд ч тодорхой хэмжээнд сөргөөр нөлөөлж эхлээд байна.



Учир нь махнаас авах уураг, шим тэжээлийг хангалттай сайн задалж, боловсруулахын тулд бидэнд дасгал хөдөлгөөн, хүйтэн ширүүн уур амьсгал, хүнд хүчир биеийн хөдөлмөр чухал байдаг. Гэтэл хүйтний улиралд хотын иргэд бид нэг газраас нөгөө газарт хүрэхдээ богино замыг бага хугацаанд туулан дулаан газар ажиллаж, амьдарч байна. Дээрээс даяарчлалын нөлөө Монголчууд бидний хооллох соёлд мөн нэвтрэх болсон. Хэрэв та анзаарсан бол бидний хооллох хэв маягт сүүлийн 30 жилийн хугацаанд томоохон өөрчлөлтүүд гарсан байна. Орон орны гал тогооны сонголтууд, кофе, цайны шинэ соёлууд гээд зарим нь бүр цоо шинэ амьдралын хэв маяг бидний хоол хүнсний хэрэглээнд тогтжээ. Эдгээр өөрчлөлтүүд бидэнд сайн сайхан зүйлс, шинэ амт, таашаалыг өгч байгаа хэдий ч зохистой хэрэглээ, тунг нь тааруулахыг шаардсаар байна. Яагаад гэвэл Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гарсан өвчлөлийн талаарх судалгаанаас харахад Монголчууд ходоодны хорт хавдрын өвчлөлөөрөө дэлхийд 2-рт, нас баралтын тоогоороо 1-рт эрэмбэлэгдэж байна. Жил ирэх тусам ходоодны үрэвсэл, шарх, хавдрын өвчлөл залуужиж нэмэгдэх хандлагатай байгаа талаар салбарын мэргэжилтнүүд ч дурддаг. Шалтгаан нь та бидний юуг, яаж идэж байгаатай шууд холбоотой учраас өдөр тутмын хүнсэндээ архаарал хандуулах цаг ирсэнийг сануулж байна. Ходоодны хүчил

шүлтийг хоол хүнсээрээ дамжуулан тэнцвэржүүлэх боломжтой ба тухайлбал бууцай, салатны навч, байцай, хулуу, чинжүү зэрэг ногоон навчит ургамлуудыг өдөр тутамдаа хэрэглэж занших эсвэл ходоодны хүчлийг багасгахын тулд ус сайн ууж хэвших нь үр дүнтэй арга билээ. Усаа уухын өмнө тухайн усны савлагаан дээрх pH буюу хүчиллэгийн хэмжээг харах хэрэгтэй. Ихэнх усны хүчиллэг pH нь 5-7-ын хооронд хэлбэлздэг ба pH нь 1 рүү ойртох тусам хүчиллэг, харин 14-т ойртох тусам шүлтлэг байна. Тэгэхээр саармаг буюу шүлтлэг ус хэрэглэвэл ходоодны хүчиллэгийг тэнцвэржүүлэхээс гадна бодисын солилцоог идэвхжүүлдэг.





МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

Үнэт цаас гаргагч:



БОДЬ ДААТГАЛ

ЭРСДЭЛИЙГ ДАВАХ ХҮЧ

Тэргүүлэгч андеррайтер:



БидиСЕК ҮЦК ХК

Андеррайтер, Брокер, Хөрөнгө оруулалтын зөвлөх

Хамтрагч андеррайтер:



GAULI
INVESTMENT
SECURITIES

ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ | IPO

Захиалга авах эцсийн хугацаа:

2020.06.08

Нэгж хувьцааны үнэ:

113₮

Татан төвлөрүүлэх хөрөнгө:

5.3 тэрбум

Үнэлгээний компани:



ГЭРЭГЭ
ЭСТИМЭЙТ

Өмгөөллийн компани:



EL LLP ADVOCATES
ОНГОЛЛИЙН ХААСХ ХҮМ

Аудит:



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Сүхбаатарын талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747-2129



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN